



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны III сарын 25 өдөр

Дугаар А/169

Номгон

Г Алба хаагчдыг туршлага судлуулахад
хөрөнгө зарцуулах тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 83 дугаар тушаалын хавсралтын 10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сүүлийн үеийн инноваци шингэсэн сэргээгдэх эрчим хүчний шийдэл Барилгын тоног төхөөрөмж, барилгын материалыг судлах зорилгоор Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц, барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэн, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчин, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэнгүүд болон Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-ны алба хаагчдыг Бүгд Найрамдах Хятад ард улсын Гуанжоу хотод болох Кантон файр олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцож туршлага судлуулахад хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцоход шаардагдах 16,500,000 /Арван зургаан сая таван зуун мянга/ төгрөгийг Барилга захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Туршлага судлах ажлын хүрээнд аймгийн хөгжлийн ерөнхий чиг хандлагын дагуу тодорхой санал боловсруулж Засаг даргын дэргэдэх удирдлагын багт 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

• 625010495